



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/174/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг:
Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: З.Ганбаатар
Утас: 70342716 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn
Аудитор:
Утас: 70342716 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 -
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.09.24 № 146
танай _____ ны № _____ Т

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.МӨНХБАТ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус хэлтэст 2022 онд Үндэсний Статистикийн хорооноос 80,000.0 мянган төгрөгийн авто машин, ҮСХ/202211007 дугаартай гэрээний дагуу 29,699.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 246.0 мянган төгрөгийн бараа материалыг тус тус үнэ төлбөргүй орлогоор бүртгэн ажилласан байна.

Мөн 11,666.7 мянган төгрөгийн авто машин элэгдлээрээ зардлаа нөхсөн тул Булган Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 03 -ны өдрийн XII/15 дугаар тогтоолд үндэслэн хөрөнгийг акталсан байна.

006020183

Аудитын гол асуудал

Тус байгууллага 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 3 зорилтын хүрээнд 31 ажил төлөвлөснөөс 31 ажлыг биелүүлж биелэлт 97.3 хувийн биелэлттэйгээр тайлагнасан байна.

2022 онд улсын төсвөөс 109,864.9, нэмэлт санхүүжилтээр 207,018.4 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан, 2022 онд авлагын дансны эхний үлдэгдэл 1,212.4 байсан бол тайлант оны эцсээр авлага, өглөгийн үлдэгдэлгүй байна.

Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,760,431.50</u>	<u>1,794,000.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	1,548,000.00	1,794,000.00
354	Хангамжийн материал	1,548,000.00	1,794,000.00
35420	Аж ахуйн материал	888,000.00	1,134,000.00
35470	Бусад хангамжийн материал	660,000.00	660,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>38,562,514.05</u>	<u>125,930,664.46</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	38,562,514.05	125,930,664.46
392	Биет хөрөнгө	38,562,514.05	125,930,664.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,666,666.79	80,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,666,666.79	-5,333,333.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,788,073.00	85,488,061.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20,164,211.47	-36,640,428.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,611,400.00	6,611,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,672,747.48	-4,195,035.12
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>41,322,945.55</u>	<u>127,724,664.46</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>41,322,945.55</u>	<u>127,724,664.46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	41,322,945.55	127,724,664.46
512	Хуримтлагдсан үр дүн	41,322,945.55	127,724,664.46
51210	Өмнөх үеийн үр дүн	41,322,945.55	41,322,945.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	86,401,718.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>41,322,945.55</u>	<u>127,724,664.46</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	207,142,418.00	426,829,288.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,783,970.00	109,945,988.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,783,970.00	109,945,988.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,783,970.00	109,945,988.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,783,970.00	109,945,988.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	197,358,448.00	316,883,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	99,524,400.00	109,864,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	99,524,400.00	109,864,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,834,048.00	207,018,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,834,048.00	207,018,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	208,460,391.97	340,427,569.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	208,460,391.97	340,427,569.09

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	208,098,166.97	331,159,398.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	84,778,873.88	88,151,066.50
210101	Үндсэн цалин	55,614,541.69	63,018,677.97
210102	Нэмэгдэл	18,541,166.76	16,375,905.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,420,236.93	3,333,000.00
210104	Урамшуулал	6,202,928.50	5,423,482.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,149,094.62	10,174,061.06
210201	Тэтгэврийн даатгал	8,138,999.09	6,956,350.89
210202	Тэтгэмжийн даатгал	843,800.00	818,394.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	675,000.09	654,715.46
210204	Ажилгүйдлийн даатгал	168,700.00	158,599.93
210205	Эрүүл мэндийн даатгал	1,322,595.44	1,586,000.57
2104	Хангамж, бараа материалын зардал	13,900,243.00	49,656,479.0
210401	Бичиг хэрэг	514,300.00	216,100.00
210402	Тээвэр, шатахуун	11,201,043.00	49,646,959.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,767,300.00	442,420.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	417,600.00	351,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	29,400.00
210604	Урсгал засвар	00.00	29,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,121,280.00	160,565,854.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,026,705.00	158,625,289.09
210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,875.00	74,090.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	19,800.00	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	950,900.00	1,950,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,148,675.47	22,582,537.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,724,300.00	250,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,424,375.47	22,331,837.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	362,225.00	9,268,170.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	244,000.00	244,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	244,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	118,225.00	9,024,170.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,225.00	9,024,170.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,317,973.97	86,401,718.91
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1,317,973.97	86,401,718.91

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	197,358,448.00	316,883,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	197,358,448.00	316,883,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	99,524,400.00	109,864,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	99,524,400.00	109,864,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,834,048.00	207,018,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,834,048.00	207,018,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	197,358,448.00	316,883,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	197,358,448.00	316,883,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	196,996,223.00	307,615,129.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	85,775,650.00	88,151,066.50
210101	Үндсэн цалин	55,750,500.00	63,018,677.97
210102	Нэмэгдэл	19,273,200.00	16,375,905.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,294,200.00	3,333,000.00
210104	Урамшуулал	6,457,750.00	5,423,482.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,391,300.00	10,174,061.06
210201	Тэтгэврийн даатгал	8,016,200.00	6,956,350.89
210202	Тэтгэмжийн даатгал	843,800.00	818,394.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	675,000.00	654,715.46
210204	Ажилгүйдлийн даатгал	168,700.00	158,599.93
210205	Эрүүл мэндийн даатгал	1,687,600.00	1,586,000.57
2104	Хангамж, бараа материалын зардал	12,288,493.00	49,656,479.00
210401	Бичиг хэрэг	514,300.00	216,100.00
210402	Тээвэр, шатахуун	9,589,293.00	48,646,959.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,767,300.00	442,420.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	417,600.00	351,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	29,400.00
210604	Урсгал засвар	00.00	29,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,816,480.00	159,353,422.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,801,905.00	157,412,857.59
210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,875.00	74,090.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	870,900.00	1,765,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,724,300.00	250,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,724,300.00	250,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	362,225.00	9,268,170.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	244,000.00	244,000.00

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	244,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	118,225.00	9,024,170.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	118,225.00	9,024,170.85
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	42,640,919.52	00.00	42,640,919.52
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	42,640,919.52	00.00	42,640,919.52
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,317,973.97	00.00	-1,317,973.97
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	41,322,945.55	00.00	41,322,945.55
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	41,322,945.55	00.00	41,322,945.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	41,322,945.55	00.00	41,322,945.55
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	86,401,718.91	00.00	86,401,718.91
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	127,724,664.46	00.00	127,724,664.46

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	109,864,900.00	307,859,129.15
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	109,864,900.00	307,859,129.15
210	Бараа, үйлчилгээний зардал	109,620,900.00	307,615,129.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,890,400.00	88,151,066.50
210101	Үндсэн цалин	65,025,600.00	63,018,677.97
210102	Нэмэгдэл	20,222,100.00	16,375,905.73
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	4,579,200.00	3,333,000.00
210104	Урамшуулал	5,063,500.00	5,423,482.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,876,500.00	10,174,061.06
210201	Тэтгэврийн даатгал	8,076,100.00	6,956,350.89
210202	Тэтгэмжийн даатгал	950,100.00	818,394.21
210203	ҮОМШӨ ний даатгал	760,100.00	654,715.46
210204	Ажилгүйдлийн даатгал	190,000.00	158,599.93
210205	Эрүүл мэндийн даатгал	1,900,200.00	1,586,000.57
2104	Хангамж, бараа материалын зардал	1,613,200.00	49,656,479.00
210401	Бичиг хэрэг	216,100.00	216,100.00
210402	Тээвэр (шатахуун)	603,600.00	48,646,959.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	442,500.00	442,420.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	351,000.00	351,000.00
2106	Эд хогшил худалдан авах	29,400.00	29,400.00
210604	Урсгал засвар	29,400.00	29,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	960,700.00	159,353,422.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	157,412,857.59
210803	Даатгалын үйлчилгээ	96,000.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	74,900.00	74,090.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	19,800.00	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	770,000.00	1,765,000.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	250,700.00	250,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,700.00	250,700.00

	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	244,000.00	244,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	244,000.00	244,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	244,000.00	244,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	109,864,900.00	316,883,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	109,864,900.00	109,864,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	109,864,900.00	109,864,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	207,018,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	207,018,400.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	6	6
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	5	5

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206,451,216.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206,451,216.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,451,216.59
2104	Хангамж, бараа материалын зардал	48,043,359.00
210402	Тээвэр, шатахуун	48,043,359.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	158,407,857.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	157,412,857.59
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	995,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	207018400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	207,018,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	207,018,400.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тухайн жил 3 зорилтын хүрээнд 31 ажил төлөвлөснөөс 31 ажлыг биелүүлж биелэлт 97.3 хувиар дүгнүүлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 1.1 “Энэ хуулийн зорилт нь Монгол улсын Статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, статистикийн байгууллага, мэдээлэгчийн бүрэн эрхийг тогтоож, тэдгээрийн хооронд болон хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр хангах явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Албаны үйлчилгээний нэр, төрөл гэвэл:

- Статистикийн мэдээлэл
- Статистикийн үйл ажиллагаа
- Статистикийн мэдээлэгч
- Статистикийн мэдээллийг хэрэглэгч
- Албан ёсны статистикийн мэдээлэл гэх мэт нэр төрөлтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Статистикийн хэлтэс 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн байна*.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган аймгийн Статистикийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109,066.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	1,5480	1,794.0	246.0
Үндсэн хөрөнгө	74,066.1	125,930.6	51,864.5
Нийт хөрөнгө	41,322.9	127,724.6	86,401.7
Өр төлбөр		0	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	41,322.9	127,724.6	86,401.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	41,322.9	127,724.6	86,401.7

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 246.0 мянган төгрөгөөр, 51,864.5 үндсэн хөрөнгө мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Тайлангийн хугацаанд үнэ төлбөргүйгээр 246,0 мянган төгрөгийн бараа материал орлогод авч 31,797.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Тайлант онд шилжсэн, шилжүүлэн авсан өөрчлөлтгүй, акталж устгасан бараа материал байхгүй болно.

Мөн Үндэсний Статистикийн Хорооноос 80,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий авто машин, 29,699.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 264.0 төгрөгийн бараа материалыг тус тус орлогод бүртгэж ажилласан байна.

Булган аймгийн Статистикийн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 219,686.8 мянган төгрөгөөр буюу 206.0 хувиар, нийт зардал өмнөх оноос 131,967.1 мянган төгрөгөөр буюу 61.2 хувиар тус тус өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймгийн Статистикийн хэлтэс нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 104,190.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 104,190.2 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 5,674.7 мянган төгрөгөөр нэмж 109,864.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 109,864.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, нэмэлт санхүүжилтийн орлого 207,018.4 нийт 316,883.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 307,859.1 мянган төгрөгийг зарцуулж, 9,024.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд 316,883.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээний зардалд зарцуулснаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 88,151.06 мянган төгрөг нийт зардлын 27.8 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 10,174.06 мянган төгрөг нийт зардлын 3.2 хувь, хангамж бараа материалын зардалд 49,656.5 мянган төгрөг нийт зардлын 15.7 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 159,353.4 мянган төгрөг нийт зардлын 50.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	109,864.9	101,407.9	8,456.9	92.3
2	Нэмэлт санхүүжилт	207,018.4	206,451.2	567.2	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлого 207,018.0 мянган төгрөгөөс өрхийн судалгааны урамшуулал, албан томилолт, цалингийн зардалд 157,412.9, тээвэр шатахуунд 23,369.4, Улсын хэмжээнд зохион байгуулагдсан хөдөө аж ахуйн

тооллогыг аймгийн нийт 16 сум 1 тосгонд гүйцэтгэж тус сумдад 24,674.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн Статистикийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 4,753.2 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 3,564.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь баталсан төсвөөс 9,024.2 мянган төгрөгийн хэмнэж ажилласан байна.

Аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тухайн жилд шилэн дансанд 151 мэдээллийг бүрэн оруулж мэдээлсэн байна

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд гэрээний дагуу төгрөгийн шатахууны худалдан авалт хийж 3 хувийн шатахууны буцаан авалт болох 797,000.0 төгрөгийн шатахууныг нярвын тайланд тусгаагүй анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Булган аймгийн Статистикийн хэлтэс нь 2022 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 32 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	378.4	1	378.4	100
Албан шаардлага	2	3,000.0	2	3000.0	100
Зөвлөмж	0	0	0	0	0
Нийт дүн	3	3,378.4	3	3,378.4	100

Хэрэгжээгүй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгө болон бараа материалыг хагас болон жилийн эцсийн тооллогоор тооцоо бодсон акт үйлдэж ажилласан эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 911.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 911.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт 1 зөвлөмж өглөө.

